

СҮХБААТАР АЙМГИЙН ДАРЬГАНГА СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

2023 оны 09 дүгээр сарын мэдээлэл

2023.09.25.

“Овоот”

Нэг. ТӨРИЙН УДИРДЛАГЫН ЧИГЛЭЛЭЭР.

-УИХ-ын гишүүн Ж. Батсуурь, Ганибал аймаг, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгчид сумын Багуудын өдөрлөгүүдэд оролцож, иргэдэд цаг үеийн мэдээлэл хийж, Багийн Засаг дарга нар, Соёлын төв, Хөдөө аж ахуйн тасагт тус бүр нэг, нийт 6 зөөврийн компьютер гардуулж өглөө.

-Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг болох Усны газрын устай холбоотой 5 заалт бүхий уриалгыг хүлээн авч, хэрэгжилт үр дүнг тооцон ажиллах чиглэлээр холбогдох байгууллага, ажилтанд үүрэг чиглэлээ өгөв.



-Шинэ сэргэлтийн бодлогын Худасгуур төвийн “Төрийн албаны чанарын цахим судалгаа”-нд хангалтгүй оролцсон асуудалд дүн шинжилгээ хийж байна.

-Consumer education center төвийн “Иргэн бүрт эрүүл мэнд” уриантай “Ажлын байран дахь хоол зүйн зохистой хэрэглээ, эрүүл амьдралын зөв дадал, зуршил, ашигт эрдэс менералуудын давуу тал нууцыг таньж мэдэх нь” туршилт сургалт суманд зохион байгуулагдах байсан ч төрийн албан хаагчид оролцоогүйд дүгнэлт хийнэ.

-Хууль эрх зүйн сургалт, сурталчилгааны ажлын чиглэлээр

Дарьгангын БЦГ-ын хамгаалалтын захиргаанаас "Уур амьсгалын өөрчлөлт ба эмэгтэйчүүд" уулзалт хэлэлцүүлгийг зохион байгууллаа. Уулзалт хэлэлцүүлэгт Сүхбаатар аймгийн ХАА-н хоршоологчдын холбооны дарга Л.Халтар Улсын тэргүүний “Алтан цацал хоршооны” үйл ажиллагааны танилцуулга, хоршиж

ажиллахын ач холбогдол, "Төрөлх нутагтаа сайхан амьдрах боломж" сэдвээр илтгэл тавьж харилцан ярилцаж мэдээлэл өглөө.



Багуудын өдөрлөгийн үед: ЕБС-иас дараахь чиглэлээр сурталчилгаа хийв.

1. Боловсролын Ерөнхий хууль дахь эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн эрх, үүрэг
2. Бага боловсролын 3-4 дүгээр ангид хэрэгжих математикийн "EDUTEN" хөтөлбөрийн танилцуулга
3. 5-6 дугаар ангид хэрэгжих англи хэлний "Pearson" хөтөлбөрийн танилцуулга
4. Оюутан элсүүлэх шинэ журмын танилцуулга
5. Дотуур байрын танилцуулга,
6. Хүүхдийн хөгжил, хамгаалал дахь эцэг эхийн оролцоо зэрэг брошурыг бэлтгэн давхардсан тоогоор 268 эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид хүргэлээ.



Соёл, боловсролын чиглэлээр:

ЕБСургууль "БОЛОВСРОЛЫН ШИНЭ СЭРГЭЛТИЙН ЖИЛ ба БАЙГУУЛЛАГЫН МЕНЕЖМЕНТ" багш, ажилчдын зөвлөгөөнийг 2023.09.05 нд зохион байгуулав. Зөвлөгөөнөөр:

1. Боловсролын ерөнхий хуулийн танилцуулга
2. Өнгөрсөн хичээлийн жилийн үйл ажиллагаанд хийсэн SWOT-шинжилгээ, анхаарах асуудал

3. 2023-2024 оны хичээлийн жилийн үйл ажиллагааны төлөвлөлт /өнгөрсөн хичээлийн жилийн төгсгөл дээр хамт олноороо хэлэлцэн төлөвлөсөн байсан/
4. Байгууллагын менежментийн загвар, сайжруулах санаа
5. 2023-2024 оны хичээлийн жилийн бүтэц, шинэчлэн баталсан сургалтын төлөвлөгөө
6. "Eduten" хөтөлбөр 3-4 дүгээр ангид хэрэгжинэ
7. Багш, ажилтан, албан хаагчдын мөрдөх шинэчилсэн "Ёс зүйн дүрэм" зарим анхаарах асуудал
8. Бага ангийн сурагчдын "Үдийн хоол" хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд анхаарах асуудал

9. 2023-2024 оны хичээлийн жилд мөрдөх шинээр гарсан дүрэм, журам "Оюутан элсүүлэх журам", "Ерөнхийлөгчийн нэрэмжит тэтгэлэг", "Шагнал олгох журам"
10. Англи хэлний "Pearson" хөтөлбөр 5-6 дугаар ангид хэрэгжинэ
11. Статистик мэдээ тайланг хийхэд анхаарах асуудал
12. Хичээл сургалттай холбоотой анхаарах зарим асуудал
13. Сургуулийн хүүхэд хамгааллын бодлого, анхаарах асуудал
14. Хүүхэд хамгаалалтай холбоотой шинээр гарсан бодлого шийдвэр, дүрэм журам
15. Анги бүлгийн сурагчдын эрсдэлийг үнэлэх арга, аргачлал
16. Сурагчдын өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагааг эрчимжүүлэх, дэмжих, хамтран ажиллах санаа
17. Хүүхдийн хөгжил, хамгааллыг дэмжих чиглэлээр зохион байгуулах үйл ажиллагааны төлөвлөлт зэргээр илтгэл тавьж, хамтран хэлэлцлээ.

2023.09.21нд Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор зохион байгуулагддаг "Мөрөөдлийн гоол-2023"- сургуулийн аварга шалгаруулах Хөл бөмбөгийн тэмцээн 5-10-р ангийн хүүхдийн эрэгтэй, эмэгтэй төрлөөр зохион байгуулагдаж, Ерөнхийлөгчийн зөвлөх, Монголын хөл бөмбөгийн холбооны ерөнхийлөгч М.Болд, хөл бөмбөгийн холбооны зөвлөх Д.Тэрбаатар, СБ аймгийн хөл бөмбөгийн холбооны нарийн бичгийн дарга Ц.Өсөхбаяр, шүүгч Ганболор нар оролцож баг тамирчдад амжилт хүсч хөл бөмбөгийн холбооноос бөмбөг, хувцас, хэрэглэгдэхүүнийг гардуулан өглөө.

2023.09.08 наас Сургууль орчинд үе тэнгийн дээрэлхэл, гэмт хэрэг зөрчлөөс сэргийлэх зорилгоор ахлах ангийн сурагчид "School police" үйл ажиллагааг зохион



байгуулж байна.

Эрүүл мэндийн чиглэлээр.

2023.09.14 нд сумын ЭМТ-өөс "Бага насны хүүхдийн нэмэгдэл хоол" танхимын сургалтыг дараах төрлөөр зохион байгууллаа.

1. Нэмэгдэл хоололт нь хүүхдийн өсөлт хөгжил, тархины хөгжил, хоол тэжээл, хөдөлгөөний болон мэдрэхүйн хөгжилд нэн чухал ач холбогдолтой байдаг . 6 сар хүрмэгц нэмэгдэл хоолыг өгч эхлэнэ . Иймд 5 болон 6 сар хүрч буй хүүхдийн эцэг , эхчүүдрүү чиглэсэн " Бага насны хүүхдийн нэмэгдэл хоол " сургалт

2. Хүнс, хоолны аюулгүй байдлыг хангах 5 түлхүүр зарчим сургалт

Цусны даралт ихсэлт гэж юу вэ?, үе шат,нөлөөлөх хүчин зүйлс, хүндрэл , урьдчилан сэргийлэх

2023.09. 20 нд дараахь чиглэлээр иргэдэд сургалт хийв. Үүнд: Цусны даралт ихсэлт гэж юу вэ? үе шат, нөлөөлөх хүчин зүйлс, хүндрэл, урьдчилан сэргийлэх нь:

Гэрийн нөхцөлд даралтыг хэрхэн шалгах вэ? дадлага сургуулилалт хийв.

Хөдөө аж ахуйн чиглэлээр:

Сумын аюулгүйн нөөцөд 20 тн өвс татаж нөөцлөх ажил хийгдэж байна.

Төв суурингийн өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд байгууллага, аж ахуйн нэгжийн нэгдсэн халаалт, дулааны асуудалд холбогдох мэргэжлийн байгууллагаар зөвлөгөө өгүүлэх арга хэмжээг авч байна.

МЭДЭЭЛЭЛ БИЧСЭН МЭРГЭЖИЛТЭН Д. МӨНХЗУЛ

ТАНИЛЦСАН ЗАСАГ ДАРГА Д. БОЛДБААТАР